



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГЯШУУНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын галбай 1, Төрийн ордон
Утас: 28-70-16, Факс: 32-70-16
E-mail: stalegrees@ulsaib@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025.03.28 № 14

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ
үзүүлэхтэй холбоотой тулгамдаж буй
асуудлын талаар асуулга хүргүүлэх
тухай

Монгол Улсын хэмжээнд өрхийн эрүүл мэндийн 224 төв, тосгоны эрүүл мэндийн 20 төв, сумын эрүүл мэндийн 307 төв, дүүрэг, аймаг, бүсийн 31 эмнэлэг, лавлагаа шатлалын үндэсний төвүүд иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байна.

Харин Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүтээр сарын 23-ны өдрийн 03, 04 тоот тогтоолууд гарснаар иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй авахад хүндрэл учирсан, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах иргэдийн тоо, санхүүжилтийг хязгаарласан байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гол ачааллыг үүрч байгаа улсын санхүүжилт, өмчлөлтэй эмнэлгүүдийг санхүүгийн дутагдал, хүндрэлд оруулж, үйл ажиллагаанд нь хүндрэл учруулж, доголдуулан, өмчийн ялгаа үүсгэж байгаад харамсаж байна.

Иймд эрүүл мэндийн даатгалын сангаас лавлагаа шатлалын болон аймаг, хотын өрх, сум, сум дундын, эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хурлын 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт зөвснэг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх анхан, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын сангаас олгох төсөв тоо, хэмжээг хязгаарласнаар иргэд тусламж, үйлчилгээг хүртээмжтэй авахад хүндрэл учруулж байгааг хэрхэн шийдвэрлэх талаар;
2. Өдрийн эмчилгээний зардалтай дүйцэхүйц хэмжээний зардлаар 1 хүний хэвтэн эмчлүүлэх зардлыг тооцож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний

2025000022

зардалд суурь тариф тогтоон хязгаарлаж байгаа нь бодит тооцоо, судалгаанд үндэслэсэн эсэх талаар;

3. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 2025 онд санхүүжүүлэх төсөө 2024 оноос 20-30 хувиар бууруулсны үндэслэл, тайлбар;
4. 2025 онд гэрээлэх төсөө, тоо хэмжээг тохирох боломжгүй байгааг хэрхэн шийдвэрлэх талаар.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлж, цаашид Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Г.ТЭМҮҮЛЭН

Ж.ЧИНБҮРЭН

2025000022